

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН
ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

Нэг. Удиртгал.....	3
Хоёр. татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо.....	4
2.1. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох.....	6
2.2. Гарах зардлыг урьдчилан тооцох.....	9
2.3. Үр дүнг тооцох.....	12
2.4. Хялбарчлах боломжийг шалгах.....	12
Гурав. Нэгдсэн дүгнэлт.....	13
3.1. Төрийн байгууллагад үүсэх зардлын тухайд	14
3.2. Хуулийн этгээд болон иргэнд үүсэх зардлын тухайд	15
3.3. Зардал-үр өгөөжийн харьцаа.....	15
Эх сурвалж.....	16

НЭГ. УДИРТГАЛ

Хууль тогтоомжийн тухай хууль¹-ийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Татварын ерөнхий хуульд² нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/ батлагдсан нөхцөлд түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хуулийн төслийн үр нөлөөг урьдчилан тандан судлах явцад гүйцэтгэх нь тухайн эрх зүйн зохицуулалтын үр нөлөөгөөр хүрэхийг хүссэн үр дүн, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгоход зарцуулах зардлын харьцааг тогтооход чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү үнэлгээний зорилго нь хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад шинээр үүсэх зардлын ачааллыг урьдчилан тооцож, цаашид гарах зардлыг багасгах санал боловсруулахад оршино.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход доор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан:

- иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;³
- үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;⁴
- бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;⁵
- аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.⁶

Аргачлалын Ерөнхий зүйлийн 1.5-д заасан журмын дагуу зардлыг (1) төрийн байгууллагын зардал, (2) хуулийн этгээдийн зардал, (3) иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог.

Аргачлалд заасны дагуу хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх этгээдэд үүсэх зардал, ачааллыг тооцох зорилгоор хуулийн төслөөс иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тодорхойлоход иргэн, хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэх

¹ 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт, өөрчлөлт орсон Хууль тогтоомжийн тухай Монгол Улсын хууль <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11119>

² 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр батлагдаж, 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон Татварын ерөнхий хууль <https://legalinfo.mn/mn/detail/14403>

³ Аргачлалын 2.3, 4.3 дахь хэсэг

⁴ Аргачлалын 2.4.4, 4.4 дэх хэсэг

⁵ Аргачлалын 4.4.3.1 дэх дэд заалт

⁶ Аргачлалын 2.1, 4.1 дэх хэсэг

зохицуулалт тусгагдаагүй тул хуулийн хэрэгжилтэд аливаа нэмэлт болон шинэ зардал гарахааргүй байна.

Харин тус хуулийн төсөлд төрийн байгууллага буюу татварын албаны хэрэгжүүлэх нэмэлт чиг үүргийг тодорхойлон тусгасан тул зардал тооцох шаардлагатай зохицуулалтуудыг түүвэрлэн, аргачлалын дагуу зардал тооцсон болно.

ХОЁР. ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Аргачлалын 4.1-д зааснаар Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцож гаргах бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

- 4.1.төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
- 4.2.уг чиг үүргийг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
- 4.3.гарах зардлыг урьдчилан тооцох;
- 4.4.зардлыг нэгтгэн тооцох;
- 4.5.хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулахаар тогтоосон.

“Гүйцэтгэх үүрэг” гэдэгт хуулийн төслөөр төрийн байгууллагад даалгасан ажил, үйлчилгээг ойлгох ба Аргачлалын 4.4.6-д заасны дагуу хууль тогтоомжийн төсөлтэй холбогдуулан шийдвэр гаргахад төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоо хийхэд оруулаагүй болно.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслөөс үнэлгээ хийх зохицуулалтыг сонгохдоо хэрэгжүүлэх чиг үүрэг, хэмжих боломжтой ажил, үйлчилгээг тусгасан зохицуулалтыг сонголоо. Үүнд, хуулийн төсөл батлагдсанаар тодорхой төрийн байгууллага, субъектэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсхүл тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор шинэ хэлтэс, нэгж бий болгох шаардлагатай эсэх зэрэг зардал үүсгэж болохуйц зохицуулалтууд хамаарна.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 8/63 дугаар зүйлийн 63.5, 11/76¹ дугаар зүйлийн 76^{1.3}, 76^{1.4} дэх хэсэг, 13/77¹ дугаар зүйлийн 77^{1.1.4}, 77^{1.1.5}, 77^{1.2} дахь заалт нь улсын төсөвт зардал үүсгэх боломжтой, төрийн байгууллагын буюу Монголын татварын албаны гүйцэтгэх чиг үүрэг /ажил, үйлчилгээ/-т хамааралтай байх ба тухайн чиг үүрэгтэй холбоотой стандарт үйл ажиллагааг тодорхойлж. Үүнд:

Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт	Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа
---	---------------------------------	------------------------

Хуулийн төслөөр Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулсан хэсэг		
Чиг үүрэг 1 63.5. Дансны битүүмжлэлийг цуцалсан талаар харьяалах татварын албаны даргын шийдвэр гарсан бол татварын алба шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 1 өдөрт багтаан шийдвэрийн хувийг татвар төлөгчид цахимаар эсхүл цаасаар гардуулж, 24 цагийн дотор тухайн харилцагч банканд хүргүүлнэ	Монголын татварын алба	• Дансны битүүмжлэлийг цуцалсан шийдвэр гаргах • Шийдвэрийг хувийг татвар төлөгчид гардуулах, мэдэгдэх • Харилцагч банканд цуцалсан шийдвэрийг хүргүүлэх
Чиг үүрэг 2 76¹.3. Хууль даган мөрдөлтийн түвшнийг тооцох шалгуур үзүүлэлтийг энэ хуулийн 35.11-т заасан журмын дагуу шинэчилж, татвар төлөгчид мэдээлнэ. 76¹.4. Татварын алба нь татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийн түвшнийг сар, улирал, жилээр тодорхойлж, татвар төлөгчид цахим татварын системээр мэдэгдэнэ. 77¹.1.4. Татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийн түвшин буурах нөхцөл бүрдсэн, татварын эрсдэлийн үнэлгээнд сөргөөр нөлөөлсөн тохиолдолд энэ талаар татвар төлөгчид мэдэгдэж, татварын тайлан, ногдлоо засах, зөрчлөө арилган татварын эрсдэлээс сэргийлэх боломж олгох;	Монголын татварын алба	• Татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийн түвшинг шинэчлэх • Шинэчилсэн хууль даган мөрдөлтийн түвшинг цахим татварын системд хөрвүүлэх • Хууль даган мөрдөлтийн түвшин болон буурах эрсдэлийг татвар төлөгчдөд мэдэгдэх
Чиг үүрэг 3 77¹.1.5. татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх боломжийн талаар татвар төлөгчид мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор хиймэл оюун ухаан болон их өгөгдөлд суурилсан, 24 цагийн турш тасралтгүй ажиллах автомат хариулагчийг ажиллуулах	Монголын татварын алба	• Татвар төлөгчид хүргүүлэх мэдээлэл, зөвлөгөөг боловсруулах • Татварын албаны үйл ажиллагаанд ашиглах хиймэл оюун ухааны платформыг тодорхойлох • Тус хиймэл оюун ухааны программ хангамжид боловсруулсан мэдээлэл, зөвлөгөө, их өгөгдлийг таниулах • Системийн хэвийн байдлыг тухай бүр ханган ажиллах
Чиг үүрэг 4 77¹.2. Энэ хуулийн 77 ¹ .1-д заасан гарын авлага, зөвлөмж, сургалтын материал, дүрс бичлэг, сургалтыг брайль үсэг, дохионы хэлийг ашиглах шаардлагад нийцүүлэн	Монголын татварын алба	• Татвар төлөгчдөд хүргэх гарын авлага, зөвлөмж, сургалтын материал, дүрс бичлэгийг боловсруулах

хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэдээлэл тэгш авах эрхээр хангасан байна.		• Боловсруулсан материалыг брайль үсэг, дохионы хэлэнд хөрвүүлэх • Хөрвүүлэгдсэн материалыг татвар төлөгчдөд түгээх
---	--	--

2.1. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 8/63 дугаар зүйлийн 63.5, 11/76¹ дугаар зүйлийн 76¹.3, 76¹.4 дэх хэсэг, 13/77¹ дугаар зүйлийн 77¹.1.4, 77¹.1.5, 77¹.2 дахь заалт болон 5 дугаар зүйлээр Монголын татварын албанд холбогдох дараах чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг чиг үүрэг тус бүрээр тодорхойлъё.

Чиг үүрэг 1. Монголын татварын албаны дансны битүүмжлэлийг цуцалсан шийдвэрийг татвар төлөгч болон харилцагч банканд гардуулах, хүргүүлэх үйл ажиллагаа (Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 8/63 дугаар зүйлийн 63.5)

Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 307 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Өртэй татвар төлөгчийн хөрөнгө битүүмжлэх, хураах, хадгалах, хамгаалахтай холбогдох харилцааг зохицуулах журам”⁷-ын 5.5-т “Банк битүүмжлэх мэдэгдэх хуудсанд заасан шаардлагыг бүрэн биелүүлсэн бол татварын албанд мэдэгдэнэ”, 5.6-д “Татварын алба энэ журмын 5.5-д заасан банкны мэдэгдлийг үндэслэн ажлын гурван өдрийн дотор битүүмжлэх мэдэгдэх хуудсыг цуцалсан тухай банканд болон татвар төлөгчид мэдэгдэнэ” гэж заасан ба тус зохицуулалтын хүрээнд битүүмжлэлийг цуцлах тухай мэдэгдлийг татварын алба хэрэгжүүлэн ажиллаж байх тул хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 8/63 дугаар зүйлийн 63.5-д заасан гүйцэтгэх үүрэг нь тухайн байгууллагад шинээр үүрэг үүсгээгүй зохицуулалт байна.

Иймд хуулийн төсөлд заасан тухайн үүргийг бусад захиргааны хэм хэмжээний актаар нарийвчлан зохицуулсан төдийгүй практикт хэрэгжиж, хэвшсэн ажил үүрэг гэсэн үндэслэлээр хүний нөөцийн нэмж зардал үүсэхгүй гэж үзлээ.

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
Монголын татварын алба	Дансны битүүмжлэлийг цуцалсан шийдвэр гаргах	-	-	-
	Шийдвэрийг хувийг татвар төлөгчид гардуулах, мэдэгдэх	-	-	-

⁷ [ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ /Өртэй татвар төлөгчийн хөрөнгө битүүмжлэх, хураах, хадгалах, хамгаалахтай холбогдох харилцааг зохицуулах/](#)

	Харилцагч банканд цуцалсан шийдвэрийг хүргүүлэх	-	-	-
Нийт				0

Чиг үүрэг 2. Хууль даган мөрдөлтийн түвшинг тодорхойлох, шинэчлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хууль даган мөрдөлтийн түвшин буурах, татварын эрсдэлийн үнэлгээнд сөргөөр нөлөөлсөн, нөлөөлөх нөхцөл бүрдсэн тохиолдолд татвар төлөгчид мэдээлэх үйл ажиллагаа (Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 11/76¹ дугаар зүйлийн 76^{1.3}, 76^{1.4}, 13/77^{1.1.4} дэх заалт)

2019 оны ТЭХ-ийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлснээс хойш Монголын татварын алба нь “Татварын скоринг”-ийг Эрсдэлийн удирдлагын хорооны 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны шийдвэрээр үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэгжүүлж байна.

“Татварын скоринг” нь татвар төлөгч аж ахуйн нэгжийн татварын хууль тогтоомж мөрдөлтийн түүх болон бусад мэдээлэлд тулгуурлан татвар төлөгчдийг үнэлэх, оноожуулах арга хэрэгсэл.

Тодруулбал, татвар төлөгчийн үндсэн бүртгэл, санхүүгийн болон татварын тайлагнал, ногдуулалт, төлөлт, хяналт шалгалтын мэдээлэл, өмнөх жилийн үнэлгээ зэрэг үндсэн шалгуур үзүүлэлтээр 100 онооноос хасагдах зарчмаар үнэлэн, А,В,С,D гэх түвшинд тодорхойлж, тухайн татвар төлөгчид цахим татварын системээр мэдээлэх цогц үйл ажиллагаа юм.

Тухайн Монголын татварын албаны хэрэгжүүлж буй үйл ажиллагааг Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлтийн төсөлд боловсронгуй болгон үүрэгжүүлэн тусгасан тул хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 11/76¹ дугаар зүйлийн 76^{1.3}, 76^{1.4}, 13/77^{1.1.4} дэх заалт”-д заасан гүйцэтгэх үүрэг нь тухайн байгууллагад шинээр үүрэг үүсгээгүй зохицуулалт байна.

Иймд хуулийн төсөлд заасан тухайн үүргийг Монголын татварын алба тасралтгүй 4 жилийн хугацаанд хэрэгжүүлж байгаа тул практикт хэрэгжиж, хэвшсэн ажил үүрэг гэсэн үндэслэлээр хүний нөөцийн нэмж зардал үүсэхгүй гэж үзлээ.

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
Монголын татварын алба	Татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийн түвшинг шинэчлэх	-	-	-
	Шинэчилсэн хууль даган мөрдөлтийн түвшинг цахим	-	-	-

	татварын системд хөрвүүлэх			
	Хууль даган мөрдөлтийн түвшин болон буурах эрсдэлийг татвар төлөгчдөд мэдэгдэх	-	-	-
Нийт				0

Чиг үүрэг 3. Монголын татварын албаны зөвлөн туслах чиг үүргийг хиймэл оюун ухаанаар үзүүлэх, тасралтгүй горимоор ажиллах автомат хариулагчийг ашиглах (Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 13/77¹.1.5)

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 271 дүгээр тушаалаар Татварын ерөнхий газрын Олон нийттэй харилцах төвийг байгуулж, мөн Татварын ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/03 дугаар тушаалаар Олон нийттэй харицах асуудал хариуцсан харьяа нэгжийн үндсэн чиг үүргийг баталсан.

Олон нийттэй харилцах төв нь татвар төлөгчийн утсаар, цахим хэлбэрээр болон биеэр ирж татварын албанаас үзүүлж буй үйлчилгээ, татварын хууль тогтоомжийн талаар асуусан асуулт, ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч татварын хууль тогтоомжийн хүрээнд мэдээлэл, зөвлөгөө өгөх, шийдвэрлэх, холбогдох арга хэмжээг авах ажлыг албаны хэмжээнд зохион байгуулах, албан вэб сайт болон олон нийтийн сүлжээ (facebook, twitter, youtube, болон тусгай дугаарын автомат хариулагч)-д цаг тухай бүр мэдээ, мэдээллийг тавих, мэдээллийн ил тод байдлыг хангах гэх мэт чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Монголын татварын албаны хэрэгжүүлж буй дээрх үйл ажиллагааг ТЕХ-ийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд боловсронгуй болгон үүрэгжүүлэн тусгасан тул хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 13/77¹ дугаар зүйлийн 77¹.1.5 дахь заалт"-д заасан гүйцэтгэх үүрэг нь тухайн байгууллагад шинээр хүний нөөц шаардахгүй тул практикт хэрэгжиж, хэвшсэн ажил үүрэг гэсэн үндэслэлээр хүний нөөцийн нэмж зардал үүсэхгүй гэж үзлээ.

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
Монголын татварын алба	Татвар төлөгчдөд хүргэх гарын авлага, зөвлөмж, сургалын материал, дүрс бичлэгийг боловсруулах	-	-	-
	Боловсруулсан материалыг брайль үсэг, дохионы хэлэнд хөрвүүлэх	-	-	-

	Хөрвүүлэгдсэн материалыг татвар төлөгчдөд түгээх	-	-	-
Нийт				0

Чиг үүрэг 4. Монголын татварын алба нь боловсруулсан гарын авлага, зөвлөмж, сургалтын материал, дүрс бичлэг, сургалтыг брайль үсэг, дохионы хэлийг ашиглах шаардлагад нийцүүлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэдээлэл тэгш авах эрхээр хангах үйл ажиллагаа (Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 13/77^{1.2})

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 271 дүгээр тушаалаар Татварын ерөнхий газрын Олон нийттэй харилцах төвийг байгуулж, мөн Татварын ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/03 дугаар тушаалаар Олон нийттэй харицах асуудал хариуцсан харьяа нэгжийн үндсэн чиг үүргийг баталсан.

Олон нийттэй харилцах төв нь татварын албаны үйл ажиллагааны талаар татвар төлөгчдийг нээлттэй, шуурхай мэдээллээр тогтмол хангах, олон нийтэд татварын хууль тогтоомжийн талаар мэдээ, мэдээлэл, контент боловсруулах ажлыг холбогдох нэгжтэй хамтран хэрэгжүүлж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээх гэх мэт чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Монголын татварын албаны хэрэгжүүлж буй дээрх үйл ажиллагааг ТЕХ-ийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд боловсронгуй болгон үүрэгжүүлэн тусгасан тул хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 13/77¹ дугаар зүйлийн 77^{1.2} дахь хэсэг"-т заасан гүйцэтгэх үүрэг нь тухайн байгууллагад шинээр хүний нөөц шаардахгүй тул практикт хэрэгжиж, хэвшсэн ажил үүрэг гэсэн үндэслэлээр хүний нөөцийн нэмж зардал үүсэхгүй гэж үзлээ.

2.2. Гарах зардлыг урьдчилан тооцох

Хуулийн төсөлд улсаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардлыг тооцно.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Материаллаг зардал гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардал ба үүнд ажлын байрны түрээсийн төлбөр, эд хөрөнгийн элэгдэл хорогдол, цахилгаан дулаан, бичиг хэрэг, техник, тоног төхөөрөмж, урсгал болон хөрөнгө оруулалт гэх мэт зардлуудыг ойлгодог.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 8/63 дугаар зүйлийн 63.5, 11/76¹ дугаар зүйлийн

76^{1.3}, 76^{1.4} дэх хэсэг, 13/77¹ дугаар зүйлийн 77^{1.1.4}, 77^{1.1.5}, 77^{1.2} дахь заалт"-д заасан Монголын татварын албаны хэрэгжүүлэх **Чиг үүрэг 1-ээс 4-д** заасан үйл ажиллагаа нь тасралтгүй хэрэгжих буюу Аргачлалын 4.4.5.2-т заасан тохиолдлын тоог тогтоох боломжгүй ажил үйлчилгээнд хамаарах ба нэмэлтээр хүний нөөцийн зардал гарахгүй, ачаалал нэмэгдэхгүй тул хүний нөөцийн зардалтай уялдах материаллаг зардал шаардагдахгүй юм.

Харин Аргачлалын 4.5.3-т заасны дагуу харин бусад зардал гэж тухайн ажил, үйлчилгээг гүйцэтгэхэд дагалдан гарах зардлыг хэлнэ. Үүнд: тухайн ажил, үйлчилгээг гүйцэтгэхтэй холбогдуулан хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх гэх мэт зардлыг ойлгодог.

Чиг үүрэг 1. Татварын өртэй 1 татвар төлөгчийн арилжааны банкн дахь данс битүүмжлэлийг цуцалсан мэдэгдлийг татвар төлөгчдөд гардуулах, харилцагч банканд хүргүүлэхэд (12 банк*1 татвар төлөгч*4500 төгрөгийн шуудангийн зардал) 58,500 төгрөгийн шуудангийн зардал гардаг гэж үзвэл 2024 онд 8,219 татвар төлөгчийн данс битүүмжилсэн ба үүнээс тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд жилд **480.8** сая төгрөгийн шуудангийн зардал гарахаар байна.

Хялбарчлах боломжийн талаар. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 8/63 дугаар зүйлийн 63.5-т заасан өртэй татвар төлөгчийн арилжааны банкн дахь данс битүүмжлэлийг цуцалсан шийдвэр, мэдэгдлийг цахимаар, эсхүл цаасаар татвар төлөгчид мэдэгдэх боломжтой ба Татварын бүртгэлийн нэгдсэн сан, ХУР системийн мэдэгдэл хүргэх системээр дамжуулан цахимаар татвар төлөгч, харилцагч банканд хүргүүлбэл дээрх шуудангийн зардлын тооцоолол буурах боломжтой байна.

Чиг үүрэг 2. Татвар төлөгчийн татварын хууль даган мөрдөлтийн түвшинг тогтоох, мэдээлэх, түвшин буурах, татварын эрсдэлийн үнэлгээнд сөргөөр нөлөөлсөн, нөлөөлөх нөхцөл бүрдсэн тохиолдолд энэ талаар татвар төлөгчид урьдчилан мэдэгдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дараах дагалдан гарах бусад зардлыг тооцоолов.

Монголын татварын алба нь “Татварын скоринг” тодорхойлох үйл ажиллагааг **“KNIME Server High Availability (HA)”** сервер, программ хангамжийг ашиглан жилийн хугацааны давтамжтай хэрэгжүүлж байгаа ба хуулийн төсөлд тусгагдсанаар тус хууль даган мөрдөлтийн түвшинг хамгийн багадаа сарын хугацаагаар тодорхойлж, татвар төлөгчдөд цахим татварын системээр тухай бүр мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд дээрх ашиглаж буй серверийг сайжруулах шаардлагатай.

“KNIME Server High Availability (HA)” серверийн түвшин (version) ахиулахад одоогийн хувилбар дээр нэмэгдээд 2.5 сая төгрөг, программ хангамжийн лицензийн төлбөрт жилд 81.7 сая төгрөг, нийт **84.2 сая** төгрөгийн зардал гарахаар байна.

Чиг үүрэг 3. Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх боломжийн талаар татвар төлөгчид мэдээлэл, зөвлөгөө өгөх

зорилгоор хиймэл оюун ухаан болон их өгөгдөлд суурилсан, 24 цагийн турш тасралтгүй ажиллах автомат хариулагчийг ажиллуулахад дараах дагалдан гарах бусад зардлыг тооцоолов.

Монголын татварын алба хиймэл оюун ухаанд суурилсан (AI), 24 цагийн турш тасралтгүй ажиллах автомат хариулагчийг (чатбот) үйл ажиллагаандаа ашигласнаар байгууллагын хэрэгцээнд тохирсон мэдлэгийн сан үүсгэж, хэрэглэгчийн үйлдэлд дасан зохицож өөрийгөө байнга сайжруулах зөвлөн туслах системийг нэвтрүүлж, татвар төлөгчдөд мэдээлэл өгөх, хэрэглэгчийн асуултад хариулах зэрэг үйл ажиллагааг автоматжуулснаар ажилтнуудын ачааллыг бууруулж, үйлчилгээний зардлыг багасгах боломж бүрдэнэ. Мөн хэрэглэгчийн зан төлөв, сонирхлыг судлан дүн шинжилгээ хийж, байгууллагад шаардлагатай тайлан мэдээллийг бэлтгэх боломжийг бүрдүүлдэг.

Тус үйл ажиллагааг нэвтрүүлэхэд системийн хэвийн байдал, хөгжүүлэлтийг хариуцдаг, тухайн чиглэлийн мэдээллийн технологийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс үйлчилгээ авах шаардлагатай ба шаардагдах мөнгөн хөрөнгө нь 1 сарын 3 сая төгрөг ба жилээр тооцоолбол **36 сая** төгрөг зарцуулахаар байна.

Чиг үүрэг 4. Монголын татварын алба нь боловсруулсан гарын авлага, зөвлөмж, сургалтын материал, дүрс бичлэг, сургалтыг брайль үсэг, дохионы хэлийг ашиглах шаардлагад нийцүүлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэдээлэл тэгш авах эрхээр хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дараах дагалдан гарах бусад зардлыг тооцоолов.

Үндэсний статистикийн хорооны Статистикийн мэдээллийн нэгдсэн санд⁸ 2024 оны байдлаар улсын хэмжээнд 11,498 харааны бэрхшээлтэй иргэд байна. Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан жилд 4 төрлийн гарын авлага, зөвлөмж, сургалтын материалыг бэлтгэхэд нэг мэдээлэлд 3 хуудас гэж тооцоолоход нийт 137,976 хуудас бүхий мэдээллийг татварын алба олон нийтэд түгээхээр байна. Брайль үсэг хэвлэлийн үйлдвэр нь 1 нүүр мэдээллийг /760 орчим тэмдэгт багтсан/ хэвлэхэд 2500 төгрөгийг зарцуулна гэж тооцвол нийт 344.9 сая төгрөгийн зардал гарахаар байна.

Үндэсний статистикийн хорооны Статистикийн мэдээллийн нэгдсэн санд⁹ 2024 оны байдлаар улсын хэмжээнд 7,561 сонсголын бэрхшээлтэй иргэд байна. Сонсголын бэрхшээлтэй иргэдэд мэдээллийг дүрс бичлэг байдлаар түгээх учир татвар төлөгчийн тооноос хамааралгүй тул ойролцоогоор 4 төрлийн зөвлөмж, гарын авлага, холбогдох материалыг 200 мин орчим дүрс бичлэг, дохионы хэлрүү хэлмэрчлэхэд 1 цаг 70,000 төгрөгийн зардал гарна гэж тооцвол нийт 300,000 төгрөгний зардал гарахаар байна. 3 цагийн сургалтын үйл ажиллагааг хэлмэрчлэхэд 165,000 төгрөг гэж тооцвол жилд 32 удаа (татварын албаар

⁸ [Статистикийн мэдээллийн нэгдсэн сан](#)

⁹ [Статистикийн мэдээллийн нэгдсэн сан](#)

тооцоолов) сургалт зохион байгуулахад нийт зардал нь 5.3 сая төгрөгийн зардал гарахаар байна.

Иймд Монголын татварын алба хуулийн төслийн “1 дүгээр зүйлийн 13/77^{1.2}”-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд жилд дунджаар **350.2 сая** төгрөгийн зардал гарахаар байна.

2.3. Үр дүнг тооцох

Аргачлалын 4.6-д заасны дагуу зардлын нийт дүнг тооцох үе шатанд төрийн байгууллагаас гарах нийт зардлыг тооцож гаргана. Ингэхдээ өмнө тооцож гаргасан хүний нөөц, материаллаг болон бусад зардлын нийлбэрийг хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлэн тооцно.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 8/63 дугаар зүйлийн 63.5, 11/76¹ дугаар зүйлийн 76^{1.3}, 76^{1.4} дэх хэсэг, 13/77¹ дугаар зүйлийн 77^{1.1.4}, 77^{1.1.5}, 77^{1.2} дахь заалт”-д заасан Монголын татварын албаны хэрэгжүүлэх **Чиг үүрэг 1-ээс 4-д** заасан үйл ажиллагаа нэмэлтээр хүний нөөцийн зардал гарахгүй, ачаалал нэмэгдэхгүй тул хүний нөөцийн зардалтай уялдах материаллаг зардал шаардагдахгүй гэж тооцоолсон.

Харин дээрх чиг үүргийг татварын алба одоогийн бүтэц, зохион байгуулалт, ажиллах хүчний чадавхийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой гэж дүгнэсэн тул Нийт зардлыг тодорхойлох томьёонд **{Нийт зардал=(хүний нөөцийн зардал+материаллаг зардал+бусад зардал)*хүний нөөцийн хэрэгцээ}** ашиглах “хүний нөөцийн хэрэгцээ” гэх үржигдэхүүнийг чанарын үзүүлэлтэд өөрчлөлт оруулахгүйгээр 1 гэх утгаар илэрхийлэх нь зүйтэй.

Иймд дараах байдлаар НИЙТ ЗАРДЛЫГ тооцоолов. (сая төгрөгөөр)

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, чиг үүрэг	Бусад зардал (Хүний нөөц, материаллаг зардалгүй)	Хүний нөөцийн хэрэгцээ	Нийт зардал
Чиг үүрэг 1	480.8	1	480.8
Чиг үүрэг 2	84.2	1	84.2
Чиг үүрэг 3	36.0	1	36.0
Чиг үүрэг 4	350.2	1	350.2
Нийт			951.2

2.4. Хялбарчлах боломжийг шалгах

Хуулийн төслөөр Татварын ерөнхий хуулийн хассан, хүчингүй болгосон хэсэг	
3 дугаар зүйл. 2/ Татварын ерөнхий хуулийн 46 дугаар зүйлийн 46.4 дэх хэсгийг “Маргаан таслах зөвлөл нь 11 хүний бүрэлдэхүүнтэй байна. Маргаан	Тухайн зохицуулалт нь Монголын татварын албанд үүрэг үүсгээгүй ба татварын албаны бүтэц,

таслах зөвлөлийн ажиллах журам, гишүүдийн эрх, үүрэг, үйл ажиллагаанд хориглох зүйлс, нөлөөллийн мэдүүлгийн загвар, хөтлөх, шийдвэрлэх журмыг Засгийн газар батална” гэж өөрчлөн найруулсугай. 5 дугаар зүйл. 46 дугаар зүйлийн 46.8 дахь хэсгийн “тухайн шатны” гэснийг, мөн зүйлийн 46.9 дэх хэсгийн “Аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын татварын албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүн болон даргыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга,” гэснийг тус тус хассугай. 6 дугаар зүйл. ... “46 дугаар зүйлийн 46.5.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.	тогтолцоог өөрчилсөн агуулгатай тул стандарт үйл ажиллагааг тодорхойлох шаардлагагүйгээс гадна нэмэлтээр хүний нөөц, материаллаг болон бусад зардал шаардагдахгүй.
---	---

Дээрх хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтын үр дүнд Монголын татварын албаны маргаан таслах зөвлөл нь аймаг, нийслэлийн дэргэд үйл ажиллагаа эрхлэхгүй болсноор нийт 22 татварын албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөл татан буугдаж, зөвхөн Татварын ерөнхий газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөл татварын албаны урьдчилсан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхээр байна.

Татварын ерөнхий хуулийн 46 дугаар зүйлийн 46.4 дэх хэсэгт заасны дагуу Маргаан таслах зөвлөл нь ес, эсхүл 11 гишүүнтэй байхаар хуульчилсан ба одоогийн байдлаар аймаг, нийслэлийн татварын албаны дэргэдэх 22 маргаан таслах зөвлөлд хамгийн багадаа нийт 198 гишүүн ажиллаж байгаа гэж тооцвол тэдэнд олгох хуралдсан цаг тутмын хөлс дараах байдлаар хэмнэгдэх боломжтой.

Татварын ерөнхий газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/100 дугаар тушаалаар харьяа татварын албаны дэргэдэх маргаан таслах зөвлөлийн гишүүдийн хуралдсан нэгж цагийн хөлсийг 20,000 төгрөг байхаар тогтоосон.

2022-2024 оны жилийн дунджаар Аймаг, нийслэлийн татварын албаны дэргэдэх маргаан таслах зөвлөлөөс 68 тогтоол гаргасан ба нэг тогтоолыг гаргахад зарцуулах хугацааг 1 цаг гэж тооцвол жилд дунджаар нийт гишүүд тус бүр 13,398 цаг хуралдсан гэж үзнэ.

Үүний үр дүнд аймаг, нийслэлийн дэргэдэх маргаан таслах зөвлөлийн гишүүдэд олгох цагийн хөлс жилд дунджаар **268 сая** төгрөг байна.

Тухайн хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалт батлагдсанаар татварын албанаас гарах Маргаан таслах зөвлөлийн гишүүдэд олгох цагийн хөлсний зардал буюу төсвийн зардал **268 сая** төгрөгөөр буурахаар байна.

ГУРАВ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг урьдчилан тодорхойлох, зардал бууруулж, ачааллыг багасгах хувилбарын талаар санал, зөвлөмж боловсруулах зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэлээ. Ингэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ыг баримтлан тооцоолов.

3.1. Төрийн байгууллагад үүсэх зардлын тухайд

Хуулийн төслийн зардлын тооцоо хийсэн зохицуулалт нь Татварын албанд үүрэг үүсгэсэн ба үүнтэй холбогдон хэрэгжүүлэх чиг үүрэг бүрээр зардлын тооцоог хийж, судалгааны тайланд тусгасан. Тухайлбал уг хуулийн төсөл батлагдсанаар хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд татварын албанд дараах хэмжээний зардал үүсэхээр байна.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 8/63 дугаар зүйлийн 63.5, 11/76¹ дугаар зүйлийн 76^{1.3}, 76^{1.4} дэх хэсэг, 13/77¹ дугаар зүйлийн 77^{1.1.4}, 77^{1.1.5}, 77^{1.2} дахь заалт”-д заасан Монголын татварын албаны хэрэгжүүлэх **Чиг үүрэг 1-ээс 4-д** заасан үйл ажиллагаа нэмэлтээр хүний нөөцийн зардал гарахгүй, ачаалал нэмэгдэхгүй тул хүний нөөцийн зардалтай уялдах материаллаг зардал шаардагдахгүй гэж тооцоолов.

Харин тухайн чиг үүрэг, ажил, үйлчилгээг гүйцэтгэхэд дагалдан гарах бусад зардлыг бодитой, дундаж үзүүлэлтэд үндэслэн гаргасан.Үүнд:

Чиг үүрэг 1. Монголын татварын албаны дансны битүүмжлэлийг цуцалсан шийдвэрийг татвар төлөгч болон харилцагч банканд гардуулах, хүргүүлэх үйл ажиллагаанд (Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 8/63 дугаар зүйлийн 63.5) шуудангийн зардал жилд дунджаар нийт 480.8 сая төгрөг гарахаар тооцоолсон боловч цахим татварын систем, нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан мэдэгдэл хүргүүлэхэд тухайн зардал буурах боломжтой гэж дүгнэлээ.

Чиг үүрэг 2. Хууль даган мөрдөлтийн түвшинг тодорхойлох, шинэчлэх болон татвар төлөгчийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хууль даган мөрдөлтийн түвшин буурах, татварын эрсдэлийн үнэлгээнд сөргөөр нөлөөлсөн, нөлөөлөх нөхцөл бүрдсэн тохиолдолд татвар төлөгчид мэдээлэх үйл ажиллагааг (Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 11/76¹ дугаар зүйлийн 76^{1.3}, 76^{1.4}, 13/77^{1.1.4} дэх заалт) хэрэгжүүлэхэд жилд дунджаар нийт 84.2 сая төгрөгийн зардал гарахаар тооцоолов.

Чиг үүрэг 3. Монголын татварын албаны зөвлөн туслах чиг үүргийг хиймэл оюун ухаанаар үзүүлэх, тасралтгүй горимоор ажиллах автомат хариулагчийг

ашиглах (Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 13/77^{1.1.5}) үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд жилд дунджаар нийт 36.0 сая төгрөгийн зардал гарахаар тооцоолов.

Чиг үүрэг 4. Монголын татварын алба нь боловсруулсан гарын авлага, зөвлөмж, сургалтын материал, дүрс бичлэг, сургалтыг брайль үсэг, дохионы хэлийг ашиглах шаардлагад нийцүүлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэдээлэл тэгш авах эрхээр хангах үйл ажиллагааг (Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 13/77^{1.2}) хэрэгжүүлэхэд жилд дунджаар нийт 350.2 сая төгрөгийн зардал гарахаар тооцоолов.

Хуулийн төсөл батлагдсанаар Монголын татварын албанд үүсэх зардлын нийт тооцоо жилд дунджаар 951.2 сая төгрөг байх ба хуулийн төслийн 3, 5, 6 дугаар зүйлд заасан нэмэлт, өөрчлөлт батлагдсанаар батлагдсанаар татварын албанаас гарах Маргаан таслах зөвлөлийн гишүүдэд олгох цагийн хөлсний зардал буюу төсвийн зардал 268 сая төгрөгөөр буурахаар байна.

Иймд нэмэгдэх зардал болон буурах зардлын дүнг харьцуулан тооцоход хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт бий болох бодит зардал жилд дунджаар нийт **683.2 сая** төгрөг байна гэж дүгнэв.

3.2. Хуулийн этгээд болон иргэнд үүсэх зардлын тухайд

Хуулийн төсөлд иргэн болон хуулийн этгээдэд шууд болон шууд бусаар үүрэг бий болгосон заалт тусгагдаагүй буюу зохицуулалтууд нь бүхэлдээ төрийн байгууллагын үүрэгт хамааралтай байх тул Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэн болон хуулийн этгээдэд зардал үүсгэхгүй гэж үзсэн.

3.3. Зардал-үр өгөөжийн харьцаа

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвөөс тодорхой зардал шаардах боловч тухайн зардал нь эдийн засагт дарамт үүсгэхгүй ба хуулийн төслийн үр өгөөжтэй харьцуулахад харьцангуй бага зардлаар өндөр үр өгөөж хүртэх буюу нийгэмд эерэг нөлөөлөл бий болоход зарцуулагдах зардал юм. Иймд тус хуулийн төсөл батлагдсанаар холбогдон гарах зардлыг нийгэмд эерэг нөлөөлөл бүхий үр дүнтэй зардал гэж дүгнэв.

---oOo---

ЭХ СУРВАЛЖ

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Хууль тогтоомжийн тухай хууль 2015.
3. Татварын ерөнхий хууль, 2019.
4. Засгийн газрын 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт, Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал, 2016.
5. Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 271 дүгээр тушаал.
6. Татварын ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/03 дугаар тушаал.
7. Татварын ерөнхий газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/100 дугаар тушаал.
8. Татварын ерөнхий газрын 2020-2024 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан.
9. Татварын ерөнхий газрын стратеги төлөвлөгөө 2021-2024.
10. Татварын ерөнхий газрын 2025-2028 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө.
11. [Статистикийн мэдээллийн нэгдсэн сан](#)